



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ЯАМ**

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: 26 22 27, Факс: (976-51) 26 37 27,
Цахим шуудан: letter@moe.gov.mn,
Цахим хуудас: www.moe.gov.mn

2026.02.24 № 03/825

танай _____ -ны № _____ -Т

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНД

Боловсролын сайдын 2025 оны А/356 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гадаадын сургалтын байгууллагад сургалтын хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлээр суралцуулах тухай” хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж буй тушаалыг хүргүүлж байна.

Холбогдох арга хэмжээг авч ажиллана уу.

Хавсралт: 1 хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРГААГЫН
ГАЗРЫН ДАРГА **Б.АЛТАНСҮХ**



1426180630



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

“Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай”

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 128/ШШ2026/0124 дүгээр шийдвэр, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 128/ШШ2026/0071 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсролын сайдын 2025 оны А/356 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гадаадын сургалтын байгууллагад сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлээр суралцуулах тухай” хавсралтад Цогбадрахын Эрхэмбаяр – Австралийн Холбооны Улсын Квийнслэндийн их сургууль (University of Queensland)-д “Хот төлөвлөлт” мэргэжлийн бакалаврын үндсэн хөтөлбөрт 4 жил, Алтанхуягийн Эгшиглэн – Канад Улсын Торонтогийн их сургууль (University of Toronto)-д “Компьютерийн шинжлэх ухаан” мэргэжлийн бакалаврын үндсэн хөтөлбөрт 4 жил гэж тус тус нэмсүгэй.

2. Дээрх нэр бүхий суралцагчидтай холбогдох журмын дагуу гэрээ байгуулж, санхүүжилтийг цаг тухайд нь олгож ажиллахыг Боловсролын зээлийн сан /М.Төртогтох/-д даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Алтансүх/-т үүрэг болгосугай.

САЙД

П.НАРАНБЯАР

11.20101.0